



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар Р/45

Бэрх хот

Хохирлын үнэлгээ тогтоох
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн гамшигт үзэгдэл болсны улмаас иргэн, аж ахуй нэгж байгууллага, төсвийн байгууллагын эд хөрөнгөд хохирол учирсан тул үүссэн нөхцөл байдлыг судалж, үнэлгээ хийж, дүгнэлт гарган, хохирлын үнэлгээ барагдуулах ажлыг зохион байгуулах, хохирлын үнэлгээ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бахыт (Захирагчийн орлогч)

Гишүүд: А.Алтанцолмон (ГТУА 42-р ангийн Захирагч, Хошууч)

П.Янжмаа (ЗАА-ны Санхүү албаны дарга)

Э.Ичинхорлоо (ЗАА-ны Нярав)

Н.Батбилэг (Иргэний төлөөлөл)

2. Хохирлын үнэлгээг тогтоож баримтжуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ

Ч.ӨНХЖАВХЛАН

232501045